



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/164

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаар хийгдсэн Доройтсон ойд ойжуулалт хийх ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)


Д.Дэмиддагва (6 дугаар багийн Засаг дарга)

Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)

Ө.Гөлгөө (Байгаль хамгаалагч)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Очирхуяг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



САМГАЛАН